

“Халх голын дайн ба төмөр зам” олон улсын симпозиум

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн Кэмбрижийн Их сургуулийн Монгол, Өвөр Азийн судалгааны төв (Mongolia and Inner Asia Studies Unit, University of Cambridge), Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран “Халх голын дайн ба төмөр зам” сэдэвт олон улсын симпозиумыг 2014 оны 9-р сарын 3-ны өдөр ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хурлын танхимд зохион байгууллаа. Энэхүү симпозиум нь Олон улс судлалын хүрээлэн Кэмбрижийн Их сургуулийн Монгол, Өвөр Азийн судалгааны төв хоёр 2013 оноос хэрэгжүүлж буй Британий Академиас санхүүжүүлсэн олон улсын эрдэм шинжилгээний байгууллагуудын хэлхээ холбоог дэмжихэд чиглэсэн “Entangled Lines: Railways, Resource Booms, Transnational Politics in Mongolia” эрдэм шинжилгээний төслийн 2014 оны нэг гол үр дүн болж байгаа болно.

Тус симпозиумд ШУА-ийн Ерөнхийлөгч Б.Энхтүвшин, Дэд Ерөнхийлөгч Т.Дорж, Гадаад харилцааны яам, Төмөр замын удирдах газар болон ихсургууль, эрдэм шинжилгээ, судалгааны бусад байгууллагын эрдэмтэн судлаачид, оюутнуудын төлөөлөл оролцов.

Олон улсын симпозиумд Монгол Улсаас Австрали улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд, доктор Р.Болд, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Цэргийн түүх судлалын төвийн эрхлэгч хурандаа, доктор Б.Ганболд, Их Британий Кэмбрижийн Их сургуулийн профессор, доктор Урадын Э. Булаг, Япон улсын Шига мужийн Их сургуулийн профессор, доктор Бүрэнсайн, БНХАУ-ын Өвөр Монголын Их сургуулийн профессор Хөгжилт, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Төрдалай нар сонирхолтой илтгэлүүдийг тавьж хэлэлцүүлээ.

ОЛОН УЛС СУДЛАЛ

Энэхүү симпозиум нь ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад ажлын айлчлал хийж, Халх голын ялалтын 75 жилийн ойн баяр ёслолд оролцож буй чухал цаг үед болж буйгаараа онцлог, Халхын голын дайн Монгол Улсын болон Зүүн Хойд Азийн төмөр замын бүтээн байгуулалтанд үзүүлсэн нөлөөг олон улсын түвшинд анхлан хэлэлцсэнээрээ шинэлэг болсон юм. Аливаа дайн, тулалдааны эдийн засгийн асуудал ямар чухал ач холбогдолтой, шийдвэрлэх нөлөөтэй байдгийг энэхүү симпозиум харуулсанаараа танин мэдэхүй, эрдэм шинжилгээний төдийгүй улс төр, аюулгүй байдлын өндөр ач холбогдолтой хурал боллоо.

*Д. Шүрхүү,
Урадын Э.Булаг*